

## МОНГОЛ ХЭЛ, ХЭЛШИНЖЛЭЛИЙН ТЭНХИМИЙН 75 ЖИЛИЙН ОЙД

Дэлхийн 2-р дайны дараагаас энх цагийн бүтээн байгуулалтад шилжин орсон монголчууд эх хэл, бичиг үсэг, утга зохиолоо сургах, судлах үндэсний дээд мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх зорилгоор 1945 онд Монгол Улсын Их Сургуульд хэл бичгийн салбар нээсэн түүхтэй. Ийнхүү байгуулагдсан цагаас Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Ш.Лувсанвандан, Д.Чойжилсүрэн, Т.Пагва, Х.Далхжав нарын манай ахмад үеийн нэрт эрдэмтэд ажиллаж монгол хэл бичиг судлалын шилдэг бүтээлүүдээ туурвин, мөн олон зуун шавь бэлтгэснээр монгол хэлшинжлэлийг тогтолцоотой шинжлэх ухаан болон хөгжих суурийг тавьжээ. Тэр цагаас хойш социализмын үндсийг байгуулах 1950-1980-аад он, өөрчлөн байгуулалтыг хэрэгжүүлэх 1980-1990-ээд он, зах зээлд шилжин орох 1990-2000-аад он, ардчилал, хүний эрхийг баталгаажуулах 2000-аас өнөө хүртэлх эх орны хөгжлийн үе шат бүрд тухайн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэдлэг, чадвар, дадал олгох, ном, сурах бичиг зохиох, боловсон хүчин бэлтгэх үүргээ манай хамт олон нэр төртэй биелүүлсээр байна.

Эх хэлнийхээ зүй тогтлыг орчин цагийн шинжлэх ухааны үүдиэс авч үзэх, бусад хэлнүүдийн дунд эзлэх байр суурийг нь тодруулах, бүх шатны сургуульд үзэх монгол хэлний сурах бичиг зохиох, монгол хэлийг хэлний бүхий л түвшинд судлах, түвшин тус бүрээр бүтээл туурвих, бүх нийтийг бичиг үсэгт сургах онол, сургалтын аргазүйг боловсруулах, Монголын хэл, түүхэнд холбогдох харь хэлээрх сурвалжийг судлах, судлаач бэлдэх, эрдэм шинжилгээний хамгийн шинэ онол, аргазүйг судалгаандаа нэвтрүүлэх зэрэг цаг үеийн болон алс хэтийн зорилгуудыг манай тэнхимийн үе үеийн багш нар, суралцагсад, төгсөгчид амжилттай биелүүлж ирсэн юм. Тиймээс бид Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Ш.Лувсанвандан, Д.Чойжилсүрэн, Т.Пагва, Х.Далхжав, Ц.Дорж, Я.Шаарийбуу, С.Барайшир, С.Мөөмөө, Чой.Лувсанжав, Ц.Шархүү, Л.Мишиг, Т.Дашцэдэн, Д.Төмөртогоо, Г.Гантоогох, Ц.Сүхбаатар, Ж.Лувсандорж, Г.Бадан, Ш.Чоймаа, Ц.Шагдарсүрэн, М.Базаррагчаа, Ж.Баянсан, Г.Буянтогох, Д.Бадамдорж, Д.Бүрнээ нарын багш нар болон бусад олон арван төгсөгчдөөрөө ямагт бахархаж үлгэр жишээ болгон хүндэтгэж явдаг билээ.

Өдгөө Монгол хэл, хэлшинжлэлийн тэнхимд эрхлэгч Б.Түвшинтөгс, зөвлөх профессор Д.Бүрнээ, зөвлөх дэд профессор Д.Баасанбат, профессор Т.Отгонтуул, дэд профессор Б.Сарантуяа, Л.Ганчимэг, А.Пүрэвжанцан, Б.Даваасүрэн, Б.Мөнгөнцэцэг, Ч.Бямбаханд, О.Дэмчигмаа, С.Батхишиг, Э.Мөнх-Учрал, Ж.Ганбаатар, ахлах багш Г.Ариунжаргал, Ч.Баттулга, Т.Эрдэнэ-Очир, багш Т.Баяртуул, Б.Энхсувд, туслах ажилтан П.Даваадорж нар ажиллаж байгаа бөгөөд нийт багш нарын 90% нь эрдмийн зэрэг цолтой болно. Түүнчлэн манай тэнхимийн бакалаврын болон ахисан түвшний сургалт, мөн монгол хэлний бэлтгэл ангид дотоод, гадаадын 500 гаруй оюутан, магистрант, докторант суралцаж байна.

Монгол хэл, хэлшинжлэлийн тэнхимийн хамт олон академич Ш.Лувсанванданы монгол хэл судлалд нэвтрүүлсэн хэлийг бүтэц-тогтолцооны үүдиэс судлах аргыг уламжлан хөгжүүлэхийн зэрэгцээ хэлшинжлэлийн орчин үеийн онол, аргазүйг судлах, заан сургах, эх орны хэлшинжлэлийн салбарт нэвтрүүлэх талаар байнга санаачилгатай ажиллаж ирсэн билээ. Тухайлбал, сэтгэц хэлшинжлэл, угсаа хэлшинжлэл, нийгэм хэлшинжлэл, танихуйн

хэлшинжлэл, цахим хэлшинжлэл зэрэг хэлшинжлэл болон бусад шинжлэх ухааны салбар дундын чиглэлүүдийг амжилттай хөгжүүлэн бүх түвшнийхээ сургалтын хөтөлбөрт нэвтрүүлээд байна. Түүнчлэн манж судлал, төвд судлал зэрэг дорно дахин судлалын сонгодог салбарын боловсролыг суралцагчдадаа олгохын зэрэгцээ монгол хэлийг сонирхон сурах, судлан шинжлэх гадаадын иргэдэд монгол хэлээ эзэмшиүүлж байна.

Тус тэнхимийн хамт олны санал, шинжлэх ухааны дэг сургуулийн уламжлал шинэчлэл, эрдэм шинжилгээний бүтээлийн чанар зэрэг олон талыг харгалzan МУИС-ийн Монгол хэл, хэлшинжлэлийн тэнхимийг 1998 онд уг тэнхимийн ахмад багш, Төрийн соёрхолт, академич Ш.Лувсанванданы нэрэмжит тэнхим болгон баталсан юм.

Дэлхийн шилдэг их дээд сургуулиулуудын жишигт нийцүүлэх зорилгоор МУИС сургалт, судалгааны ажлын зохион байгуулалтыг өөрчилж үүнтэй холбоотойгоор Монгол хэл, хэлшинжлэлийн тэнхим ч мөн бүлгийн сургалтаас хөтөлбөрийн сургалтад шилжин орж бакалаврын түвшинд Монгол хэл, уран зохиолын багш хөтөлбөрийг Утга зохиол, урлаг судлал болон Сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухааны тэнхимтэй хамт, Хэл шинжлэл-уран зохиол судлал хөтөлбөрийг Утга зохиол, урлаг судлалын тэнхимтэй, Хэл шинжлэл хөтөлбөрийг дангаараа хэрэгжүүлж байна. Мөн ахисан түвшний сургалтад хэлшинжлэлийн хөтөлбөрөөр судалгааны болон мэргэжлийн магистрыг бэлтгэж, докторантурт хэлшинжлэлийн чиглэлээр сургаж байна. Монгол Улсын БШУЯ-аас баталдаг Хэлшинжлэлийн чиглэлээр докторын зэрэг хамгаалуулах зөвлөл тус тэнхимд түшиглэн ажилладаг билээ.

Бид хэл бичиг судлалын үндэсний боловсон хучин бэлтгэх үйлсэд хучин зүтгэхийн зэрэгцээ бусад орны судлаачдыг эх орондоо сургах, түүнчлэн гадаадын их дээд сургуульд зочин багшаар уригдан монголч эрдэмтэн, дипломат ажилтан, орчуулагч нарыг бэлдэхэд ч мөн тэргүүлэн ажиллаж ирсэн юм. Тухайлбал, Япон, Герман, Америк, Франц, Унгар, БНХАУ, ОХУ зэрэг орны их дээд сургуульд урт богино хугацаагаар тогтмол багшилж байна. Мөн хамтын ажиллагаатай гадаадын сургуулиудад оюутан сургах, дадлага хийлгэх, сургалтад хамруулах ажлыг ч цөөнгүй зохион байгуулдаг.

Монгол хэл, хэлшинжлэлийн тэнхимийн хамт олон суралцагчдадаа хөтөлбөрт тусгасан мэдлэгийг бүрэн олгохыг хичээн ажиллахын зэрэгцээ Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиуд, мэргэжлийн байгууллагуудад багшлах болон үйлдвэрлэлийн дадлага хийлгэж сурсан мэдлэгээ өөрийн болгох чадварт сургаж байна. Мөн судалгааны ажлын арга барилд сургах үүднээс оюутан суралцагчдынхаа дунд эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг тогтмол зохион байгуулж шаардлага хангасан бүтээлүүдийг нь “Монгол судлал” цувралд хэвлэн нийтэлдэг. Цаашид суралцагчдынхаа эрэлт шаардлагад нийцсэн шинэ хичээлүүдийг хөтөлбөртөө нэмж оруулах, зарим хичээлүүдээ цахим хэлбэрт шилжүүлэх, хээрийн дадлага зохион байгуулах, орчин үеийн техник тоног төхөөрөмж бүхий лаборатори байгуулах, монгол уламжлалт ахуй амьдралыг таниулах биет хэрэглэгдэхүүн бүхий анги танхим тохижуулах зэрэг ажлыг хийхээр төлөвлөж байна.

Чихний чимэг болсон аялгуу сайхан монгол хэлээ судалж чин зоригт өвөг дээдсийнхээ өв их эрдэнийг түгээн дэлгэрүүлэгч Монгол хэл, хэлшинжлэлийн тэнхимийн хамт олонд 75 жилийн ойн мэнд хүргэе!